

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	19-18
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

2025.02.24 № СЗА-2025/163/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 15 дугаар тогтоолын дагуу 317,024.4 мянган төгрөгийн Ахмадын сувиллын барилга, газар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Сүхбаатар сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь ХХҮЕГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа нь тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам

432502^50

зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт, 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	25,195,563.00	21,047,833.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,195,563.00	21,047,833.00
35400	Хангамжийн материал	25,195,563.00	21,047,833.00
35410	Бичиг хэргийн материал	3,754,250.00	5,200,900.00
35420	Аж ахуйн материал	2,564,090.00	2,910,090.00
35450	Барилгын засварын материал	313,500.00	313,500.00
35470	Бусад хангамжийн материал	18,563,723.00	12,623,343.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,437,977,076.36	1,228,742,261.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,437,977,076.36	1,228,742,261.47
39200	Биет хөрөнгө	1,371,654,910.82	1,178,678,261.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,543,030,129.86	1,254,254,618.93
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(231,548,459.85)	(236,816,831.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,733,000.00	187,733,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(187,733,000.00)	(187,733,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	260,833,092.23	384,568,686.23
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(228,274,600.04)	(238,269,831.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,125,911.65	122,723,411.65
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(102,511,163.03)	(107,781,791.91)
39300	Биет бус хөрөнгө	66,322,165.54	50,064,000.00
39301	Програм хангамж	7,655,000.00	7,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(6,300,834.46)	(7,655,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,968,000.00	50,064,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,463,172,639.36	1,249,790,094.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,463,172,639.36	1,249,790,094.47
51	Засгийн газрын хувь оролцоо	1,463,172,639.36	1,249,790,094.47
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	64,968,000.00	64,968,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,398,204,639.36	1,184,822,094.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1,470,283,994.49	1,398,204,639.36
51220	Тайлант үеийн үр дүн	(72,079,355.13)	(213,382,544.89)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,463,172,639.36	1,249,790,094.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,671,102,409.68	2,700,762,813.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	106,248,173.68	127,161,234.00
1200	Нийтлэг татварын бус орлого	106,248,173.68	127,161,234.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,700,000.00	3,840,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	98,700,000.00	3,840,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,498,173.68	123,321,234.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	50,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,564,854,236.00	2,573,601,579.00
1310	Улсын төсвөөс	1,460,571,500.00	2,321,570,770.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,460,571,500.00	2,321,570,770.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,282,736.00	252,030,809.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	42,796,620.00	219,736,663.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	61,486,116.00	32,294,146.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,743,181,764.81	2,642,927,445.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,743,181,764.81	2,642,927,445.60
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,721,523,863.30	2,246,773,306.55
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,163,246,036.78	1,744,414,359.07
210101	Үндсэн цалин	645,927,023.99	884,805,916.16
210102	Нэмэгдэл	246,068,035.23	596,539,164.15
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	122,799,712.50	145,382,121.21
210104	Урамшуулал	148,451,265.06	117,687,157.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,875,488.27	221,795,846.92
210201	Нийгмийндаатгалын шимтгэл	103,180,786.19	151,899,617.42
210202	Тэтгэмжийн даатгал	12,043,854.39	17,855,790.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,166,845.95	8,719,995.23
210204	Ажилгүйдлийн даатгал	2,279,011.53	8,664,088.83
210205	Эрүүл мэндийн даатгал	22,204,990.21	34,656,355.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,216,558.20	134,480,878.86
210301	Гэрэл, цахилгаан	8,604,748.20	5,333,487.86
210302	Түлш, халаалт	104,111,610.00	124,995,031.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,200.00	4,139,960.00
210304	Байрны түрээс	-	12,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,480,951.11	19,671,720.10
210401	Бичиг хэрэг	9,467,260.00	8,019,350.00
210402	Тээвэр, шатахуун	3,767,698.00	2,605,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,900,043.11	4,312,680.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	380,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	965,950.00	4,089,690.00
210409	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд - ТӨҮГ	-	465,000.00

2105	Нормативт зардал	41,061,620.00	5,515,000.00
210502	Хоол, хүнс	41,061,620.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,515,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,462,050.00	3,770,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	119,900.00
210604	Урсгал засвар	5,462,050.00	3,650,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,767,400.00	4,864,600.00
210702	Дотоод албан томилолт	2,767,400.00	4,864,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,904,730.13	27,100,265.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,853,681.13	25,335,946.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261,865.00	735,463.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	606,000.00	726,000.00
210807	Газрын төлбөр	64,659.00	88,081.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,509,028.81	85,160,136.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,393,100.00	3,564,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,028,650.00	900,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	79,087,278.81	80,696,136.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,657,901.51	396,154,139.05
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,187,901.51	121,179,229.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,187,901.51	121,179,229.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,470,000.00	274,974,910.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,657,466.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	-	237,877,444.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,000.00	3,440,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	271,217,912.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(72,079,355.13)	57,835,367.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	271,217,912.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	271,217,912.29
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	271,217,912.29
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(72,079,355.13)	(213,382,544.89)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,663,554,236.00	2,577,441,579.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,700,000.00	3,840,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	98,700,000.00	3,840,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,700,000.00	3,840,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	98,700,000.00	3,840,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,564,854,236.00	2,573,601,579.00
1310	Улсын төсвөөс	1,460,571,500.00	2,321,570,770.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,460,571,500.00	2,321,570,770.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,282,736.00	252,030,809.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	42,796,620.00	219,736,663.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	61,486,116.00	32,294,146.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,663,554,236.00	2,558,083,579.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,663,554,236.00	2,558,083,579.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,641,896,334.49	2,161,929,439.95
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,163,246,036.78	1,744,413,559.07
210101	Үндсэн цалин	642,371,297.99	884,805,916.16
210102	Нэмэгдэл	249,500,473.73	596,539,164.15
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	122,923,000.00	145,382,121.21
210104	Урамшуулал	148,451,265.06	117,686,357.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,875,488.27	221,795,846.92
210201	Нийгмийндаатгалын шимтгэл	102,457,423.81	151,899,617.42
210202	Тэтгэмжийн даатгал	12,043,854.39	17,855,790.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,305,083.39	8,719,995.23
210204	Ажилгүйдлийн даатгал	2,279,011.53	8,664,088.83
210205	Эрүүл мэндийн даатгал	22,790,115.15	34,656,355.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,216,558.20	134,444,478.86
210301	Гэрэл, цахилгаан	8,604,748.20	5,333,487.86
210302	Түлш, халаалт	104,111,610.00	124,971,031.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,200.00	4,139,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,820,701.11	18,542,040.10
210401	Бичиг хэрэг	8,745,850.00	9,293,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,767,698.00	2,755,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,962,303.11	4,312,680.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	380,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	964,850.00	2,000,660.00
2105	Нормативт зардал	41,061,620.00	-
210502	Хоол, хүнс	41,061,620.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,462,050.00	6,304,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-

210604	Урсгал засвар	5,462,050.00	6,304,650.00
2107	Томилолт, зочны зардал	2,767,400.00	4,864,600.00
210702	Дотоод албан томилолт	2,767,400.00	4,864,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,904,730.13	27,100,265.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,853,681.13	25,335,946.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261,865.00	735,463.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	606,000.00	726,000.00
210807	Газрын төлбөр	64,659.00	88,081.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,541,750.00	4,464,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,000,000.00	3,564,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,541,750.00	900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,657,901.51	396,154,139.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,470,000.00	274,974,910.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,657,466.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	-	237,877,444.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,000.00	3,440,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,187,901.51	121,179,229.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,187,901.51	121,179,229.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	19,358,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	19,358,000.00
22	Хөрөнгийн зардал		19,358,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		19,358,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		19,358,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	(19,358,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	2023 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	64,968,000.00	-	1,398,204,639.36	-	1,463,172,639.36
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	2023 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	64,968,000.00	-	1,398,204,639.36	-	1,463,172,639.36
8	2024 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	64,968,000.00	-	1,398,204,639.36	-	1,463,172,639.36
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,968,000.00	-	1,398,204,639.36	-	1,463,172,639.36
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(213,382,544.89)	-	(213,382,544.89)
16	2024 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	64,968,000.00	-	1,184,822,094.47	-	1,249,790,094.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,358,222,400.00	2,208,309,065.75	149,913,334.25	93.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,358,222,400.00	2,208,309,065.75	149,913,334.25	93.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,052,751,000.00	1,935,334,155.75	117,416,844.25	94.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,654,848,000.00	1,557,606,592.00	97,241,408.00	94.12
210101	Үндсэн цалин	899,646,400.00	884,805,916.16	14,840,483.84	98.35
210102	Нэмэгдэл	471,713,200.00	409,732,197.08	61,981,002.92	86.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,426,000.00	145,382,121.21	19,043,878.79	88.42
210104	Урамшуулал	119,062,400.00	117,686,357.55	1,376,042.45	98.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,305,200.00	198,507,675.79	8,797,524.21	95.76
210201	Тэтгэврийн даатгал	140,511,300.00	136,077,125.09	4,434,174.91	96.84
210202	Тэтгэмжийн даатгал	16,698,400.00	15,994,320.60	704,079.40	95.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,349,200.00	7,785,960.40	563,239.60	93.25
210204	Ажилгүйдлийн даатгал	8,349,300.00	7,730,054.00	619,246.00	92.58
210205	Эрүүл мэндийн даатгал	33,397,000.00	30,920,215.70	2,476,784.30	92.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,236,200.00	134,444,478.86	5,791,721.14	95.87
210301	Гэрэл, цахилгаан	8,521,200.00	5,333,487.86	3,187,712.14	62.59
210302	Түлш, халаалт	124,933,600.00	124,971,031.00	(37,431.00)	100.03
210303	Цэвэр, бохир ус	6,781,400.00	4,139,960.00	2,641,440.00	61.05
2104	Хангамж, бараа материалын зардал	14,327,900.00	12,483,840.10	1,844,059.90	87.13
210401	Бичиг хэрэг	4,509,000.00	4,445,500.00	63,500.00	98.59
210402	Тээвэр, шатахуун	4,184,500.00	2,695,000.00	1,489,500.00	64.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,335,100.00	3,162,680.10	172,419.90	94.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,500.00	180,000.00	60,500.00	74.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,058,800.00	2,000,660.00	58,140.00	97.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,086,700.00	25,662,650.00	3,424,050.00	88.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,228,300.00	19,358,000.00	870,300.00	95.70
210604	Урсгал засвар	8,858,400.00	6,304,650.00	2,553,750.00	71.17
2107	Томилолт, зочны зардал	4,943,000.00	4,864,600.00	78,400.00	98.41
210702	Дотоод албан томилолт	4,943,000.00	4,864,600.00	78,400.00	98.41
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,004,000.00	1,764,319.00	239,681.00	88.04
210803	Даатгалын үйлчилгээ	195,000.00	170,775.00	24,225.00	87.58
210804	Тээврийн хэрэгслийн татвар	735,700.00	735,463.00	237.00	99.97
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	48,000.00	44,000.00	4,000.00	91.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	890,300.00	726,000.00	164,300.00	81.55
210807	Газрын төлбөр	135,000.00	88,081.00	46,919.00	65.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	305,471,400.00	272,974,910.00	32,496,490.00	89.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	305,471,400.00	272,974,910.00	32,496,490.00	89.36

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,388,800.00	33,657,466.00	28,731,334.00	53.95
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	241,640,200.00	237,877,444.00	3,762,756.00	98.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,442,400.00	1,440,000.00	2,400.00	99.83
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,358,222,400.00	2,325,410,770.00	32,811,630.00	98.61
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,353,422,400.00	2,321,570,770.00	31,851,630.00	98.65
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,353,422,400.00	2,321,570,770.00	31,851,630.00	98.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,800,000.00	3,840,000.00	960,000.00	80.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,800,000.00	3,840,000.00	960,000.00	80.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	247,953,284.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	247,953,284.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	245,953,284.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	186,806,967.07
210101	Үндсэн цалин	-	13,630,427.55
210102	Нэмэгдэл	-	173,176,539.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	23,288,171.13
210201	Тэтгэврийн даатгал	-	15,822,492.33
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,861,469.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	934,034.83
210204	Ажилгүйдлийн даатгал	-	934,034.83
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,736,139.42
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,058,200.00
210401	Бичиг хэрэг	-	4,848,200.00
210402	Тээвэр, шатахуун	-	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	25,335,946.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	25,335,946.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,464,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,564,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	256,409,443.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	256,409,443.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	219,736,663.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	36,672,780.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /цаашид ХХҮГ гэх/ нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай, хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчныг бий болгож, амьжиргааны түвшинг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар **халамжаас-хөдөлмөрт** шилжих нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

ХХҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас дотоод хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХХҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь ХХҮЕГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөж эхэлснээс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон тул уг баримт бичиг нь хууль, эрх зүйн актуудтай бүрэн нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХХҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,280.0 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	25,195.56	21,662.83	(3,532.73)
Үндсэн хөрөнгө	1,437,977.08	1,228,229.76	(209,747.31)
Нийт хөрөнгө	1,463,172.64	1,249,892.59	(213,280.04)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,463,172.64	1,249,892.59	(213,280.04)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,463,172.64	1,249,892.59	(213,280.04)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 21,662.8 мянган төгрөг болж 3,532.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,659.0 мянган төгрөгийн

бараа материал худалдан авч, 23,191.7 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,228,229.7 мянган төгрөг болж, 209,747.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 18,743.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ХХҮЕГ-аас 123,321.2 мянган төгрөгийн таблет, суурин компьютер, принтер шилжүүлэн авсан, аймгийн ИТХ-ын 2024 оны 158 дугаар тогтоолоор 9 нэр төрлийн 13,001.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 15 дугаар тогтоолын дагуу 317,024.4 мянган төгрөгийн Ахмадын сувиллын барилга, газар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Сүхбаатар сумын ЗДТГ-т шилжүүлсэн, 80,593.6 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,233,568.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 130,350.0 мянган төгрөг, нийт 2,363,918.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 171,987.1 мянган төгрөг, нормативт зардлыг 14,755.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 12,943.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,000.0 мянган төгрөг зэрэг нийт 249,692.2 мянган төгрөгөөр бууруулж, 2,114,226.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 206,022.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,773.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 22,450.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 82,319.0 мянган төгрөг зэрэг нийт 342,120.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, нормативт зардлыг 32,285.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 65,839.0 мянган төгрөг, нийт 98,124.0 мянган төгрөгөөр бууруулсан зэргээр батлагдсан төсвийг нийт 243,996.4 мянган төгрөгөөр бууруулж, 2,358,222.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,358,222.4 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,358,222.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,208,309.0 мянган төгрөг буюу 93.6 хувьтай тайлагнагдсан нь нийгмийн халамж хөтөлбөрийн зардлыг 134,114.4 мянган төгрөгөөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлыг 15,799.0 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71902	Нийгмийн халамж	2,087,272.90	1,953,158.51	134,114.39	93.57
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,777,001.50	1,676,898.60	100,102.90	94.37
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	4,800.00	3,285.00	1,515.00	68.44
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	305,471.40	272,974.91	32,496.49	89.36
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	270,949.50	255,150.55	15,798.95	94.17
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	270,949.50	255,150.55	15,798.95	94.17
	Дүн	2,358,222.40	2,208,309.07	149,913.33	93.64

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130017406 тоот дансанд аймгийн санхүүгийн дэмжлэгээс орон нутгийн нэмэгдэл цалинд 214,469.7 мянган төгрөг, Ерөө сумаас халамжийн 2 мэргэжилтний орон нутгийн нэмэгдэл цалинд 3,267.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс аймгийн Засаг даргын 2024 оны А/18 дугаар захирамжаар шилдэг байгууллагын шагналд 2,000.0 мянган төгрөг, ХХҮЕГ-аас сэтгэл ханамжийн үнэлгээний системийн зардалд 350.0 мянган төгрөг, АДЗ-ийн ажлын хөлс, өрхийн судалгааны санхүүжилтэд 35,422.8 мянган төгрөг, ХЭДС-аас бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн зээлийн өмнөх сургалтын зардалд 900.0 мянган төгрөг, нийт 256,409.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 186,806.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 23,288.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 6,058.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,464.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 25,336.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 2,000.0 мянган төгрөг, нийт 247,953.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,456.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд тус газарт шууд худалдан авах босго үнээс буюу 20,000.0 мянган төгрөгөөс давсан худалдан авах ажиллагаа хийгдээгүй тул тухай гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ХХҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,743,181.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,431.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарыг аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарыг авч, ашиглах зөвлөмж хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ХХҮГ-ын мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 28 төрлийн 182 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, “Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан” мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдын улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг **10,773.1** мянган төгрөгөөр илүү олгосон зөрчилд төлбөрийн акт, өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг **2,250.0** мянган төгрөгөөр тасалсан зөрчилд албан шаардлага хүргүүлснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10,773.1	1	10,773.1	100
Албан шаардлага	1	2,250.0	1	2,250.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	13,023.1	2	13,023.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг **дээд шатны төсвийн захирагчийн** санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ХХҮЕГ-аас тус газарт шилжүүлэн томилогдсон ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Батсайханд ХХҮЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/186 дугаар тушаалаар мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийг 40 хувиар тооцож, олгож байсныг үндэслэн нэмэгдлийг бууруулахгүйгээр үргэлжлүүлэн олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Өмнөх оны ажлыг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 50.0 хүртэл хувиар тооцож, үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал дээд шатны байгууллагуудын удирдах албан тушаалтны шийдвэрүүдээр урамшууллыг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.3: “*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ХХҮЕГ-ын даргын 2024 оны А/256 дугаар “2023 оны балансын урамшуулал олгох тухай” тушаалаар төсвийн үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч Б.Идэрчулуунд 1,471.0 мянган төгрөг, халамжийн сан хариуцсан мэргэжилтэн П.Өлзийжаргалд 1,260.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.
- Аймгийн Засаг даргын 2024 оны А/18 дугаар захирамжийн 4 дүгээрт “2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр эхний байрт шалгарсан агентлагийн даргыг 1 сар хүртэлх албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн шагналаар шагнаж, урамшуулах” гэж заасныг үндэслэн дарга Л.Зоригтбаатарт 1,757.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарыг авч, ашиглаагүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	-					2	-